



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2025/007/НА-СТА-ТТЗ**

Чингис хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.Хараат бус аудиторын дүгнэлт .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан Эрүүл мэндийн төв
ЭМТ	



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 516

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Цэнхэрмандал сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын 267,996.8 мянган төгрөг, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 138,372.6 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 1,586,407.5 мянган төгрөг нийт 1,992,776.9 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн, өргөн тархсан байна. Үүнд:

Засаг дарга нь малын тоо толгойн албан татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд дутуу төвлөрүүлсэн, сангийн оны эхний үлдэгдлийг дутуу төлөвлөсөн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хувийн эзэмшлийн хашааг сольсон, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийн 5-аас дээш жилийн насжилттай чанаргүй зээлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй, батлагдсан төсвийг илүү хуваарилсан, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, түр ажилтанд нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон, эд хариуцагчийн хувийн харилцах дансанд төсвийн хөрөнгийг шилжүүлж зарцуулсан, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх арга хэмжээ аваагүй, шилэн дансны цахим системд мэдээллийг дутуу байршуулсан.

Засаг даргын тамгын газар нь цалингийн санг НДШ-ийн тайланд зөрүүтэй тайлагнасан, цалингаас суутгасан НДШ-ийг ажил олгогчийн төлөх шимтгэлийн зардлаас төлсөн, төсвийн хөрөнгийг спортын наадам, уралдаан тэмцээнд зарцуулсан, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг дутуу тоолж, баталгаажуулсан, шилэн дансны цахим системд мэдээллийг дутуу мэдээлсэн, эд хариуцагчийн дансанд төсвийн хөрөнгийг шилжүүлэн зарцуулсан, төрийн үйлчилгээний албан хаагчаар төрийн захиргааны албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас Цэнхэрмандал сумын 100 жилийн ойд зориулж 90.0 сая төгрөгийг наадмын зардалд зарцуулсан, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 36 төсөл арга хэмжээнээс 22 төсөл арга хэмжээний 353.5 сая төгрөгийн санхүүжилтийг 40-100 хувиар урьдчилж олгосон зөрчил илэрснийг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэж Прокурорын байгууллагад шилжүүлэхээр уламжилсан болно.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.", 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно"

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.",

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 70.2.1-т 1/

үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана."

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.", 48 дугаар зүйлийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх;"

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.9-д "орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр",

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно", 13.3.2-т "хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ", 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ."

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;"

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.7.3-т "Төсвийн хуваарь нь нэгдсэн дүнгээр батлагддаг төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг тухайн төрийн сангийн нэгж нь төсвийн батлагдсан хуваарьтайгаа сар бүр тулгаж, хянана", 3.6.6-д "Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна;"

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.13-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь барилга, байгууламжийн төслийн хувьд гэрээний үнийн дүнгийн 30 хувь хүртэл байх бөгөөд тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн дүнгээс ихгүй байна;"

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “2101-цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамаарна”, 2102- ажил олгогчоос тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан хэмжээгээр үнэдсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос албан журмаар төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ.”

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4-т “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.” гэж заасныг зөрчиж, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн орлогоос 1,009,744.9 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс 1,035,873.4 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгээс 945,765.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 25,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 616,584.3 мянган төгрөг нийт 3,632,968.3 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийн тодотголоор аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 83,208.1 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 299,594.3 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн орлогыг 41,002.9 мянган төгрөгөөр, урьд үлдэгдлийг 11,250.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 3,302,418.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн авч 2,827,775.8 мянган төгрөгийг зарцуулж, 156,092.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,066,129.0 мянган төгрөгийн 37 алдаа, зөрчил илрүүлснээс 1,361,647.8 мянган төгрөгийн 11 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 5,105.6 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 2,699,375.6 мянган төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд нийт 607,847.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 339,850.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 529.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 121,024.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 146,442.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг төлөвлөж, 83.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,263,522.48	1,076,231.72
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	638,311.36	538,756.04
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	446,152.93	270,228.46
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	21,500.0	100,500
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	157,558.2	159,747.22
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	-	7,000.00
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,757,927.03	6,841,747.32
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,757,927.03	6,841,747.32
9	1.2.2.02 Биет хөрөнгө		6,318,349.03	6,198,862.58
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	439,578	642,884.74
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		8,021,449.51	7,917,979.04
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		39,290.46	283,463.45
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		39,290.46	283,463.45
14	2.1.1.03 Өглөг		291.54	247,895.74
15	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	38,998.93	35,567.72
16	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,982,159.05	7,634,515.59
17	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		7,982,159.05	7,634,515.59
18	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		1,603,076.42	1,607,258.42
19	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		34,230.5	34,230.50
20	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		6,301,281.9	5,949,456.45
21	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		43,570.22	43,570.22
22	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		8,021,449.51	7,917,979.04

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		7,085,062.57	3,905,252.58
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		861,153.17	749,246.94
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		375,810.8	373,533.35
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		375,810.80	373,533.35
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		105,517.18	79,295.81
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		379,825.19	296,417.78
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	4,531,165.91	3,156,005.64
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.00	959,123.31
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,692,743.49	0.00
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,232,032.27	2,786,956.93
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		2,232,032.27	2,786,956.93
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,157,772.70	2,746,480.37
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		813,157.43	934,467.44
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		105,574.27	126,201.81
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		333,213.05	352,944.91
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		60,794.27	49,609.76
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		1,657.10	8,998.00
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		77,320.59	67,802.08
19	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		22,983.00	17,703.40
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		261,021.20	260,405.98
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		482,051.79	928,346.99
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		74,259.57	40,476.56
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,853,030.30	1,118,295.65
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		456,205.47	1,470,121.11
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-456,205.47	-1,470,121.11
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		4,396,824.83	-351,825.46

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**
**/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,048,124.55	3,099,958.25
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	861,153.17	749,246.94
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	375,810.80	373,533.35
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	105,517.18	79,295.81
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	379,825.19	296,417.78
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,186.08	27,008.39
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	300,983.28	228,339.13
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	43,655.83	41,070.26
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	494,227.89	2,350,711.31
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	494,227.89	745,916.59
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	958,623.31
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	646,171.40
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,692,743.49	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,899,590.70	2,188,248.12
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,899,590.70	2,188,248.12
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,825,331.13	2,145,845.56
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	836,999.43	1,016,341.38
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,207.07	117,044.31
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,208.43	352,888.60
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	180,101.91	267,567.88
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,807.10	8,998.00
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	70,941.49	78,121.08
23	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	22,981.00	15,510
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,380.24	180,894.88
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	134,704.46	108,479.42
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,259.57	42,402.56
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,148,533.85	911,710.13
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	734,966.13	951,265.44
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	734,966.13	951,265.44
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	734,966.13	951,265.44
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(734,966.13)	(951,265.44)
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	139,700.0	60,000
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(139,700.00)	(60,000.00)
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	273,867.72	(99,555.31)
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	364,443.63	638,311.36
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	638,311.36	538,756.04

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,585,780.09		3,585,780.09
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,585,780.09		3,585,780.09
3	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-445.88		-445.88
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	4,396,824.83		4,396,824.83
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,982,159.05		7,982,159.05
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,982,159.05		7,982,159.05
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,982,159.05		7,982,159.05
8	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,182.00		4,182.00
9	1.7 Тайлант үеийн үр дүн	-351,825.46		-351,825.46
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,634,515.59		7,634,515.59

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,674,584.5	2,721,163.25
2	3.1.01.1.1 Татварын орлого	730,747.8	749,246.94
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	358,500.00	373,533.35
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	358,500.00	373,533.35
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	270,000.00	283,990.52
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	55,000.00	49,934.69
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	25,000.00	30,232.07
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	5,000.00	5,196.07
9	3.1.01.1.1.1.1.06 Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	3,500.00	41,800.00
10	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	111,250.00	79,295.81
11	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10,000.00	15,783.73
12	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	1,250.00	1,470.00
13	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	100,000.00	62,042.08
14	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	260,997.80	296,417.78
15	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,000.00	27,008.39
16	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	6,000.00	5,177.14
17	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5,000.00	262.59
18	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	20,000.00	21,568.67
19	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	200,000.00	228,339.13
20	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	200,000.00	228,339.13
21	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	29,997.80	41,070.26
22	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	23,157.80	29,124.82
23	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	6,840.00	11,945.44
24	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,943,836.70	1,971,916.31
25	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	345,000.00	373,079.61
26	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	300,000.00	269,526.25
27	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	20,000.00	76,650.47
28	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	5,000.00	11,820.00
29	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	20,000.00	15,082.89
30	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	952,665.30	952,665.30
31	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	952,665.30	952,665.30
32	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	646,171.40	646,171.40
33	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	646,171.40	646,171.40
34	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,302,418.90	3,013,473.65
35	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,058,911.00	2,075,992.72
36	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,010,603.90	1,850,013.68
37	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,001,306.10	927,637.88
38	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	388,454.10	376,942.47
39	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	376,872.50	352,048.80
40	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	28,413.30	22,963.40
41	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	68,686.00	34,209.08
42	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	138,880.20	141,474.12
43	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,140.50	117,044.31
44	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	85,088.20	79,013.50
45	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	10,013.00	9,530.04
46	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	5,006.60	4,869.95
47	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	5,006.60	4,752.64
48	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	20,026.10	18,878.19
49	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	361,920.20	352,846.81
50	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	56,150.00	50,407.20
51	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	297,670.10	294,505.61
52	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	8,100.10	7,934.00
53	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	51,447.50	43,884.59
54	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	6,111.30	5,052.26
55	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	32,015.60	27,093.73
56	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,352.20	4,946.10
57	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,045.00	600.00

58	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,923.40	6,192.50
59	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	9,200.00	8,998.00
60	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,200.00	8,998.00
61	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	128,391.30	126,808.59
62	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	27,520.60	26,938.41
63	3.1.01.2.1.1.6.02 Тавилга	20,000.00	20,000.00
64	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,943.10	2,943.10
65	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	77,927.60	76,927.08
66	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	20,548.90	15,510.00
67	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	20,548.90	1,510.00
68	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,825.60	156,537.61
69	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,168.60	152,589.98
70	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-
71	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	800.00	800.00
72	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	800.00	599.50
73	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	300.00	266.00
74	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.30	1,381.40
75	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	1,200.00	900.73
76	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	113,823.80	100,745.90
77	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	108,169.30	96,366.40
78	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,654.50	4,379.50
79	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,307.10	225,979.04
80	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,000.00	198,793.22
81	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,000.00	13,095.32
82	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	185,697.90
83	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	33,307.10	27,185.82
84	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,147.10	24,240.22
85	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,160.00	2,945.60
86	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,172,009.40	877,480.93
87	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	1,172,009.40	877,480.93
88	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	71,498.50	60,000.00
89	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	71,498.50	60,000.00
90	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(627,834.40)	(292,310.40)
91	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	627,834.40	292,310.40
92	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	627,834.40	292,310.40
93	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	636,847.12
94	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	530,234.62

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдсан дүн
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>34,810,807.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,810,807.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	33,210,090.08
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,803,890.08
210402	Тээвэр, шатахуун	1,803,890.08
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,730,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,730,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,676,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,676,200.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,600,716.92</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,600,716.92
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>34,810,807.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,810,807.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,378,736.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,432,071.00

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 2 орон нутгийн өмчит, 1 төрийн сангийн, 3 тусгай сан нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай”, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС, ЭМТ-ийн санхүүгийн тайланд Платиниум прогресс аудит ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

Сумын ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв, Ойн анги, Цэнхэрмандал хөгжил ОНӨҮГ аудитын түүвэрт хамрагдсан болно.

**3.1 Тус сумын харьяа орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 3,381,081.9 мянган төгрөгийн 27 алдаа, зөрчил илэрснээс 1,342,176.3 мянган төгрөгийн 8 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 2,637,910.9 мянган төгрөгийн зөрчилд 17 албан шаардлага, 994.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:**

#### Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн аудитын асуудлаар илэрсэн зөрчлийг байгууллагаар харуулбал:

#### **Засаг даргын тамгын газар**

1. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор тоног төхөөрөмж дансны 233,287.7 мянган төгрөгийн үлдэгдлийг дутуу тоолж, баталгаажуулсан.

2. Жилийн эцсийн бараа материалын тооллогоор аж ахуйн болон бусад хангамжийн материалаас бусад бараа материалын 55,584.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоо хийгээгүй.

3. Тус байгууллага нь эд хариуцагчийн хувийн харилцах дансанд 21,426.4 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан нь анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, тооцоо хийж баталгаажуулаагүй.

4. Цалингаас суутгасан 2,647.7 мянган төгрөгийн НДШ-ийг ажил олгогчийн төлөх шимтгэлийн зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчиж зориулалт бусаар зарцуулсан.

5. НДШ-ийн тайланд 3 албан хаагчийн цалинг 704.9 мянган төгрөг илүү, 5 албан хаагчийн цалинг 6,657.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

6. Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардлаас 9,585.0 мянган төгрөгийг улс, аймгийн аварга малчны шагналд, залуу гэр бүлд гэр худалдан авах, эрсдэлийн сангаас 17,500.0 мянган төгрөгийг машины сэлбэг, модны суулгац худалдан авахад зарцуулж, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүлсэн.

#### **Орон нутгийн хөгжлийн сан**

1. Цэнхэрмандал сумын 100 жилийн ойн баяр наадмын зардалд 90 сая төгрөг баталснаас засуулын дээл малгайнд 2 сая, морь барианы газрын индэрт 10 сая, сумын 100 жилийн ойн баримтад кинонд 3.5 сая төгрөг нийт 15.5 сая төгрөг өмчлөлд шилжих боломжтой бөгөөд үлдсэн 74.5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

2. Гэрээ байгуулаагүй, актаар хүлээж аваагүй 2 төсөл арга хэмжээнд 35,200.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.13 дахь заалтыг зөрчиж 22 төсөл арга хэмжээнд 30%-иас дээш дүнгээр урьдчилгаа олгосон.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлсэн.

#### **Иргэдийн төлөөлөгчдийн хурал**

1. Үндсэн үйл ажиллагааны зардал, мэдээлэл сурталчилгааны зардлаас нийт 680.0 мянган төгрөгийг хурлын төлөөлөгчийн томилолтод олгож зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Эд хариуцагч хувийн харилцах дансанд 2,022.5 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

3. Үлдэх өртөггүй 11,425.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

4. Хурлын ажлын албаны мэргэжилтэнд албан үүргийг түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг 994.8 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 1 зөвлөмж, 1 төлбөрийн акт тогтоосон.

#### **Цэнхэр хөгжил ОНӨҮГ**

Ажилтныг ажилд томилох тушаал гаргаж, хөдөлмөрийн гэрээ байгуулалгүй ажиллуулж 5,990.0 мянган төгрөгийн цалинг тавьж олгосон байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлсэн.

**3.2. Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 85,047.1 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 19,471.4 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 61,464.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 4,110.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт хүргүүлсэн. Үүнд:**

#### Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн аудитын асуудлаар илэрсэн зөрчлийг байгууллагаар харуулбал:

#### **Ерөнхий боловсролын сургууль**

1. Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 978.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

2. Сахилгын шийтгэл оногдуулсан 2 ажилтанд 530.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

#### **Цэцэрлэг**

3. Ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 4 ажилтанд 2,647.4 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.

#### **Соёлын төв**

4. Эд хариуцагчийн хувийн харилцах дансанд 675.0 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

#### **Эрүүл мэндийн төв**

5. Ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 1 ажилтанд 932.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.

Шийдвэрлэлт: Цалин давхардуулан болон сахилгын шийтгэлтэй ажилтанд олгосон цалинг нөхөн төлүүлэх 3 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлсэн.

**3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 607,847.7 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 339,850.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 121,024.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 529.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 146,442.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:**

### **3.3.1 Төлбөрийн акт**

1. Малын тоо толгойн албан татварын 529.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.*

### **3.3.2.Албан шаардлага:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл 9,012.6 мянган төгрөгийг төлөвлөөгүй байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.*

2. Батлагдсан төсвөөс сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 11.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвд 999.9 мянган төгрөг нийт 1,011.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

*Энэ нь Сангийн сайдын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.7.3-т "Төсвийн хуваарь нь нэгдсэн дүнгээр батлагддаг төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг тухайн төрийн сангийн нэгж нь төсвийн батлагдсан хуваарьтайгаа сар бүр тулгаж, хянана" гэснийг мөрдөн ажиллаагүй байна.*

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Баянмод багийн гэр хорооллын эгнээ жигдлэх манай гудамж" төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөвгүйгээр хэрэгжүүлж, айл өрхийн хашааны нүүрэн талыг битон угсармал болгон сольсон байна.

*Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно", 13.3.2-т "хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ", 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль*

*орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.*

### **3.3.3 Зөвлөмж**

1. Хоршоо хөгжүүлэх сангийн нийт зээлийн үлдэгдлээс 14 зээлдэгчийн 61,924.9 мянган төгрөг нь 5-аас дээш жилийн насжилттай чанаргүй зээлд байгааг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

*Энэ нь Сангийн сайдын 2021 оны А/361 тоот тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шлгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.3-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна.” гэснийг зөрчсөн байна.*

Шийдвэрлэлт: Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн 5-аас дээш жилийн насжилттай үлдэгдлийг төлүүлэхээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, түүний хэрэгжилтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд үйл ажиллагааны орлого 5,565.3 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 38,824.5 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4,737.4 мянган төгрөг, торгуулийн орлого 30,473.7 мянган төгрөг, бусад орлого 4,917.1 мянган төгрөг нийт 84,518.00 мянган төгрөгөөр биелээгүй байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг зөрчсөн.*

Шийдвэрлэлт: Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөх, төлөвлөсөн орлогыг төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, түүний хэрэгжилтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	440.9			1	440.9	1	440.9				
ЗДТГ	4	482,371.5	1	179,142.3	3	303,229.2	4	482,371.5				
ОНХС	2	842,586.2			2	842,586.2	2	842,586.2				
ХХС	1	16,777.7			1	16,777.7	1	16,777.7				
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>8</b>	<b>1,342,176.3</b>	<b>1</b>	<b>179,142.3</b>	<b>7</b>	<b>1,163,034.0</b>	<b>8</b>	<b>1,342,176.3</b>	-	-	-	-
Соёлын төв	3	19,471.4			3	19,471.40	3	19,471.4				
<b>УТБ-ын дүн</b>	<b>3</b>	<b>19,471.4</b>	-	<b>0.0</b>	<b>3</b>	<b>19,471.40</b>	<b>3</b>	<b>19,471.4</b>	-	-	-	-
Засаг дарга	2	339,850.9	2	339,850.9			2	339,850.9				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>2</b>	<b>339,850.9</b>	<b>2</b>	<b>339,850.9</b>	-	<b>0.00</b>	<b>2</b>	<b>339,850.9</b>	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>1,701,498.6</b>	<b>3</b>	<b>518,993.2</b>	<b>10</b>	<b>1,182,505.4</b>	<b>13</b>	<b>1,701,498.6</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	4	3,697.3	1	994.8	2	2,702.5	1					
ЗДТГ	6	345,901.8			6	345,901.8						
ОНХС	3	463,181.0			3	463,181.0						
Цэнхэр хөгжил	1	5,990.0			1	5,990.0						
<b>ОНБ-ын дүн</b>	<b>14</b>	<b>818,770.1</b>	<b>1</b>	<b>994.8</b>	<b>12</b>	<b>817,775.3</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
Соёлын төв	1	675.0			1	675.0						
ЕБС	2	1,508.6	1	530.6	1	978.0						
Цэцэрлэг	1	2,647.4	1	2,647.4								
ЭМТ	1	932.8	1	932.8								
<b>УТБ-ын дүн</b>	<b>5</b>	<b>5,763.8</b>	<b>3</b>	<b>4,110.8</b>	<b>2</b>	<b>1,653.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
Засаг дарга	6	267,996.8	1	529.5	3	121,024.4	2	146,442.9				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>6</b>	<b>267,996.8</b>	<b>1</b>	<b>529.5</b>	<b>3</b>	<b>121,024.4</b>	<b>2</b>	<b>146,442.9</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>25</b>	<b>1,092,530.7</b>	<b>5</b>	<b>5,635.1</b>	<b>17</b>	<b>940,452.7</b>	<b>3</b>	<b>146,442.9</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	134,675.3				1	134,675.3	
ОНХС	1	444,954.6				1	444,954.6	
ЗДТГ	1	1,219,797.1				1	1,219,797.1	
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>3</b>	<b>1,799,427.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>1,799,427.0</b>	<b>0</b>	<b>-</b>
ЕБС	1	59,273.0				1	59,273.0	
Цэцэрлэг	1	538.8				1	538.8	
<b>УТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>59,811.8</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>59,811.8</b>	<b>0</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,859,238.8</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>1,859,238.8</b>	<b>0</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	2	20,708.6				2	20,708.6	
Дүн	2	20,708.6	0	0		2	20,708.6	0 0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>1,879,947.4</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>1,879,947.4</b>	<b>0</b>	<b>-</b>



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 86-А2370448

Чингис хот

ХЭА-2026/007/НА-СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын орлогын 529,500.00 (таван зуун хорин есөн мянга таван зуу) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Малын тоо толгойн албан татварын орлогын 529,500.00 (таван зуун хорин есөн мянга таван зуу) төгрөгийг Төрийн сан банк дахь ерөнхий орлогын 100180700910 тоот данснаас "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 100180752400 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга А.Мөнх-Оргилд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 269-А2370448

Чингис хот

ХЭА-2026/007/НА/СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл 9,012,597.00 (есөн сая арван хоёр мянга таван зуун ерэн долоо) төгрөгийг төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга А.Мөнх-Оргилд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 270-А2370448  
ХЭА-2026/007/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвөөс сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 11,900.00 (арван нэгэн мянга есөн зуу), Эрүүл мэндийн төвд 999,900.00 (есөн зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөг нийт 1,011,800.00 (нэг сая арван нэгэн мянга найман зуу) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.7.3-т "Төсвийн хуваарь нь нэгдсэн дүнгээр батлагддаг төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг тухайн төрийн сангийн нэгж нь төсвийн батлагдсан хуваарьтайгаа сар бүр тулгаж, хянана" гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу олгодоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга А.Мөнх-Оргилд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 271- А2370448

Чингис хот

ХЭА-2026/007/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Баянмод багийн гэр хорооллын эгнээ жигдлэх манай гудамж" төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөвгүйгээр хэрэгжүүлж, айл өрхийн хашааны нүүрэн талыг бетон угсармал болгон сольсон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно", 13.3.2-т "хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ", 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хувийн өмчийн эд хөрөнгөнд хөрөнгө оруулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга А.Мөнх-Оргилд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА